

“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.04.30

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Гутал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2021.04.30-ны өдрийн 15¹⁰ минутанд “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өрөөнд эхлэв. Түүнчлэн ZOOM аппликейшнээр хувьцаа эзэмшигчид оролцов

Тус хуралд:

1. Ц.Төмөр- биечлэн
2. Т.Билэг- итгэмжлэлээр
3. Б.Батбилэг- биечлэн
4. Б.Баттөр - цахимаар
5. Б.Батхишиг - цахимаар тус тус оролцсон.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 1,497,859 ширхэг хувьцаа эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигч оролцсон ба нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 92.59 хувь болж байгаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах;
4. 2020 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах.

Хурал даргалагч: ТУЗ-ийн дарга Б.Батбилэг

СОНССОН нь:

Батбилэг: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хуралд эхэлснийг мэдэгдье. Монгол улсын Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор хурлаа биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдсэн тул хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд явья.

Гутал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг та бүхэнд цаасаар болон файл хэлбэрээр тараасан. Үүнтэй та бүхэн сайн танилцсан байхаа. Эхний хэлэлцэх асуудал Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах байгаа.

ТУЗ-ийн зүгээс дүгнэлтээ 2021 оны 03-р сарын 10-ны өдөр гаргасан. Үүн дээр хэлэх санал байна уу.

Төмөр: Санал байхгүй.

Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар батлав.

Батбилэг: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлаа ярилцъя. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос 2021 оны 03-р сарын 09-ний өдөр хуралдаж, нийт 10 хүний нэрийн дэвшүүлж байгаа. Нэр дэвшигч нарын танилцуулгатай та бүхэн танилцсан байгаа. Та бүхэн саналын хуудсаараа сонгох хүмүүсдээ саналаа өгнө үү. Онлайн оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар саналын хуудсаа бөглөөд имэйлээр наашаа илгээгээрэй. Эх хувиар нь бид өөрсдөө очоод авах болно.

ТУЗ-ийн гишүүнээр Ц.Төмөр, Б.Батбилэг, Т.Билэгт, Б.Баттөр, Б.Батхишиг, Ч.Цэцэгмаа, хараат бус гишүүнээр Э.Билгүүн, Н.Чинбат, С.Бат-Эрдэнэ нар сонгогдлоо. Баяр хүргэе.

Одоо компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах асуудал байна. Жил бүрийн ТУЗ-ийн төсөв хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагддаг. Энэ жилийн тухайд нийт 120,300,000 төгрөг байна. Өмнөх жил баталж байсан дүнтэй адилхан байгаа. Саналаа өгөх үү.

Төмөр: Санал байхгүй. Дэмжиж байна.

Баттөр: Дэмжиж байна.

Батхишиг: Татгалзах зүйл байхгүй. Дэмжиж байна.

Батбилэг: Дэмжиж байна. ТУЗ-ийн төсөв ийнхүү батлагдлаа. Хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал бол 2020 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах байна. Бид ТУЗ-ийн 2021 оны 02-р сарын 09-ний өдөр ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. 2020 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 1,120 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрлэсэн болно.

Та бүхэн одоо санал хураах хуудсаа үнэн зөв, алдаагүй бөглөж имэйлээр/шууд өгнө үү. Тооллогын комисс тооцоог нь гаргаж танилцуулах болно.

Өнөөдрийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулав. Өнөөдрийн хурал дууслаа. Баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дараах шийдвэрийг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гаргав. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгов.

1. Б.Батбилэг
2. Б.Баттөр
3. Б.Батхишиг
4. Ц.Төмөр

6. Ч.Цэцэгмаа

1. Э.Билгүүн
2. Н.Чинбат
3. С.Бат-Эрдэнэ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16³⁵ цагт дуусав.

НАРИЙН БИЧИГ А.ГУЛИМ

ХУРЛЫН ДАРГА Б.БАТБИЛЭГ